



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 05/4501 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Орхон АЗЗА”, “Булган АЗЗА”, “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Зам, тээврийн хөгжлийн яамны шинжээч Б.Минжбадам, Зам, тээврийн хөгжлийн яамны мэргэжилтэн С.Баярчимэг нарыг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001273